

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС”ХК

2014 он 02 сар 28 өдөр

№ 01

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Ноогдол ашиг тараах эсэх тухай

“Глобал Монголиа Холдингс” ХК-ийн 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар ноогдол ашиг тараах эсэх талаар хэлэлцэн 2013 оны санхүүгийн тайланд үндэслэн ноогдол ашиг тараахгүй байхаар хуралд оролцсон нийт гишүүдийн 100 хувийн саналаар баталсныг үндэслэн ТОГТООХ нь:

1. 2013 оны санхүүгийн тайлан дээр үндэслэн компанийн алдагдал 756,570,276.38 төгрөг /долоон зуун тавин зургаан сая таван зуун далан мянга хоёр зуун далан зургаан төгрөг гучин найман мөнгө/ болсон тул ноогдол ашиг тараах боломжгүй хэмээн шийдвэрлэсүгэй.
2. Ноогдол ашиг тараахгүй байх тухай хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэхтэй холбогдон гарах ажлыг удирдан зохион байгуулахыг гүйцэтгэх захирал /С.Бямбаасүрэн/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



И ЖЭГОН

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС”ХК

2014 он 02 сар 28 өдөр

№ 02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
зарлан хуралдуулах тухай*

Компанийн санхүүгийн жил дуусч байгаатай холбогдуулан компанийн тухай хуулийн 59.4-т заасны дагуу тус компанийн хувьцаа эзэмшигч нарын ээлжит хурлыг дараах маягаар зарлан хуралдуулсугай.

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2014 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагт компанийн төв байр /Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 1-р хороо Чин Ван Чагдаржавын гудамж Махаяна төв 2-3 тоот/-д хуралдуулах
2. Ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэх
 1. ТУЗ-н гишүүд болон нарийн бичгийг шинээр томилох
 2. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган хэлэлцэж батлах
 3. 2014 оны компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлах
 4. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, санхүүгийн чадамжийг сайжруулах зорилгоор хаалттай хүрээнд нэмж гаргасан хувьцааны тухай танилцуулах
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдрийг Санхүүгийн Зохицуулах Хорооны “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон Компанийн тухай хуулийн 64.2-д үндэслэн 2014 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөр тогтоох
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журмын дагуу гүйцэтгэх
5. Хурлын даргаар ТУЗ-ийн дарга И Жэ Гон-г, тооллогын комиссын гишүүдээр Д.Одгэрэл, У.Баярмаа нарыг томилох
6. Хурлын хэлэлцэх асуудлуудтай холбогдуулан хувьцаа эзэмшигч нарыг дараах материалуудтай танилцах боломжоор хангах
 - А. 2014 оны компанийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө
 - Б. 2013 оны компанийн жилийн санхүүгийн тайлан болон, үйл ажиллагааны тайлан
 - В. ТУЗ-д нэр дэвшиж буй шинэ гишүүдийн болон нарийн бичгийн тухай мэдээлэл, хувийн хэрэг

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 1 хороо
Чин Ван Чагдаржавын гудамж Махаяна төв 2-3

Утас : 11 32 54 41

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС”ХК

7. Хурлын ерөнхий зохион байгуулалт түүнтэй холбоотой ажил үүргийн гүйцэтгэлийг компанийн гүйцэтгэх захирал Сүхбатын Бямбаасүрэнд даасгасугай.

8. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой бичиг баримтыг бэлтгэх, хувьцаа эзэмшигч нарт хурлын зар хүргэх зэрэг үүргийг компанийн ажилтан Д.Одгэрэлд даалгасугай.

9. Хувьцаа эзэмшигчдийг бүртгэх, саналын хуудас бэлтгэх, санал авах, хурлын ирц бүртгэх зэрэг ажлыг зохион байгуулж гүйцэтгэх үүргийг компанийн нарийн бичиг У.Баярмаад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



И ЖЭ ГОН

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС”ХК

2014 он 02 сар 28 өдөр

№ 03

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

Гүйцэтгэх захирлыг шинээр томилдох тухай

“Глобал Монголиа Холдингс” ХК-ийн 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон нийт гишүүдийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Гүйцэтгэх захирал Паг Чан Сү-тай хийсэн хөдөлмөрийн гэрээг 2014 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосугай.
2. 2014 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Сүхбат овогтой Бямбаасүрэнг түүнтэй хийсэн хөдөлмөрийн гэрээг үндэслэн гүйцэтгэх захирлаар томилсугай.
3. Гүйцэтгэх захирал шинээр томилогдсонтой холбогдон гарах үйл ажиллагааг удирдан зохион байгуулахыг нэр дэвшүүлэх хорооны гишүүн Ким Сү Нам-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



И ЖЭГОН